

УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ ШИНЭ БУУДАЛ
 БАРИХ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГ 2018 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
 /2018 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар/

*/Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын
 15-ны өдрийн 89-р тогтоолоор батлагдсан
 журмын 5-р хавсралтын дагуу бэлтгэв/*

| № | Хөтөлбөр/Төслийн агуулга | Гүйцэтгэл |
|----|--|---|
| 1. | <p>Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл.</p> <p>-Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд тус төслийг санхүүжүүлэх зээлийн гэрээг 2008 оны 5 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан. Гэрээний дугаар MON-P8. Гэрээг Монгол Улсын Их хурал 2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр соёрхон баталсан. 2008 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс Японы тал гэрээг баталснаар зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсон.</p> <p>-Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар болон Япон Улсын Мицүбиши, Чиёода компаниудын хамтарсан түншлэл хооронд Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан.</p> <p>-Төслийг санхүүжүүлэх нэмэлт зээлийн гэрээг 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан. Гэрээний дугаар MON-P12. Гэрээг Монгол Улсын Их Хурлаар 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан. 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсон тухай Япон талаас албан ёсоор мэдэгдсэн.</p> <p>Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар болон Япон Улсын Мицүбиши, Чиёода компаниудын хамтарсан түншлэл хооронд Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээний нэмэлт өөрчлөлт №1-ыг 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт №2-ыг 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр тус тус байгуулсан.</p> | <p>Төсөл, хөтөлбөрийн зорилго:</p> <p>Далайд гарцгүй Монгол Улсын хувьд гадагш гарах гол хаалга болох чухал ач холбогдолтой нийслэл хотын нисэх онгоцны буудлын аюулгүй ажиллагаа, хүчин чадал, найдвартай, тав тухтай байдлыг сайжруулах үүднээс Монгол Улсын нийслэлд Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг газар зүйн ямар нэгэн хязгаарлалтаас ангид газар нутагт байгуулж, үүгээрээ Монгол Улсын эдийн засгийн цаашдын хөгжилд хувь нэмэр оруулах.</p> |
| 2. | Санхүүжилтийн эх үүсвэр | -Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-ын хөнгөлөлттэй зээл /MON-P8, MON-P12/: 65.6 тэрбум Япон иен -Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт: 38 тэрбум төгрөг |
| 3. | Хэрэгжүүлэгч байгууллага/Хэрэгжих нийт хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Зам, тээврийн хөгжлийн яам Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Иргэний нисэхийн ерөнхий газар |
| | Хэрэгжүүлэх нийт хугацаа | Барилгын ажлын гэрээт хугацаа: 1290 хоног /Гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр олгосон өдөр буюу 2013 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн тооцогдсон цаг хугацаа болох 1290 хоногт багтаан Ерөнхий гүйцэтгэгч үндсэн барилга, байгууламжуудын барилга угсралтын ажлыг амжилттай хэрэгжүүлэв. “Барилгын ажлын нэмэлт өөрчлөлт-1” гэрээний ажлыг 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдөр эхлүүлж 2018 оны 08 дугаар сард |

| | | | | | |
|----|-----------------------------|--|---|---------------------|--------|
| | | Улсын комисс ажилласнаар нэмэлт барилгын ажил дууссан байна. Гэрээний дагуу ажил хүлээн авах гэрчилгээ гараагүй байна. Зээлээс ашиглагдаагүй үлдэж буй хөрөнгөөр Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга барих ажлыг хэрэгжүүлж байна. | | | |
| 4. | Төслийн 2018 оны зорилтууд: | <p>Зорилт 1. Үндсэн зээлийн гэрээ /MONP-8/-ний хөрөнгөөр баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах үед улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажилд хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг гаргуулах. Чанарын баталгаажуулалтын хугацаанд илэрсэн зөрчил, дутагдлыг засварлах ажилд хяналт тавих, биелэлтийг тайлагнах.</p> <p>Зорилт 2. Зээлийн гэрээ /MONP-12/-ний хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламжийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангаж, техникийн комисс ажиллуулж дүгнэлт гаргуулах, ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулах хугацааг тодорхойлж ажиллуулах.</p> <p>Зээлийн гэрээ /MONP-12/-ний хүрээнд баригдсан барилга байгууламжийг "Барилгын тухай хууль"-ийн 14.2-д заасан хугацааны хяналтын ажлыг хэрэгжүүлэх.</p> <p>Нисэх буудлын зүлэгжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэхэд хяналт тавих.</p> <p>Улсын төсвийн болон Нэмэлт зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилгын инженерийн шугам сүлжээний ажилд хяналт тавьж хэрэгжүүлэх.</p> <p>Зорилт 3. Монголын Улсын төсвийн санхүүжилтээр баригдах Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга, Захиргааны барилга болон Аэродромын засвар үйлчилгээний барилга байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж Улсын комисс ажиллуулан ашиглалтад оруулах.</p> <p>Зорилт 4. Ангарын барилгын зураг төслийг боловсруулах баталгаажуулах ажлыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах Ангарын барилгын газар шороо, перрон, инженерийн шугам сүлжээний ажил болон барилга угсралтын ажил.</p> <p>Зорилт 5. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дотоод ажлуудыг хэрэгжүүлэх.</p> | | | |
| 5. | Зардал | Төсөв | Нийт төсөв: Зээлийн хөрөнгөөр 65.6 тэрбум иен, Монголын Засгийн газрын санхүүжилт 122.8 тэрбум төгрөг | | |
| | | Үүнд: | Төсөв /2009 он/ | Гүйцэтгэл /2009 он/ | Хувь |
| | | MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/ | - | 288.1 сая иен | 100.0% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | - | - | |
| | | Үүнд: | Төсөв /2010 он/ | Гүйцэтгэл /2010 он/ | Хувь |
| | | MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/ | - | 526.8 сая иен | 100.0% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | - | - | |
| | | Үүнд: | Төсөв /2011 он/ | Гүйцэтгэл /2011 он/ | Хувь |
| | | MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/ | 365.3 сая иен | 228.2 сая иен | 62.5% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | - | - | |
| | | Үүнд: | Төсөв /2012 он/ | Гүйцэтгэл /2012 он/ | Хувь |
| | | MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө | 657.6 сая иен | 104.8 сая иен | 16% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | 2.8 тэрбум төгрөг | 1.8 тэрбум төгрөг | 100% |

| | | Үүнд: | Төсөв /2013 он/ | Гүйцэтгэл /2013 он/ | Хувь |
|----|------------------------------|--|----------------------------|--------------------------------|-------------|
| | | MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/ | 11.9 тэрбум иен | 11.4 тэрбум иен | 100.0% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | 28.0 тэрбум төгрөг | 18.8 тэрбум төгрөг | 67.1% |
| | | Үүнд: | Төсөв /2014 он/ | Гүйцэтгэл /2014 он/ | Хувь |
| | | MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/ | 6.8 тэрбум иен | 8.2 тэрбум иен | 100% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | 16.8 тэрбум төгрөг | 8.2 тэрбум төгрөг | 50% |
| | | Үүнд: | Төсөв /2015 он/ | Гүйцэтгэл /2015 он/ | Хувь |
| | | MON-P8, MON-P12 төсөл /зээлийн хөрөнгө/ | 4.0 тэрбум иен | 7.6 тэрбум иен | 100% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | 11.2 тэрбум төгрөг | 7.2 тэрбум төгрөг | 64.3% |
| | | Үүнд: | Төсөв /2016 он/ | Гүйцэтгэл /2016 он/ | Хувь |
| | | MON-P8, MON-P12 төсөл /зээлийн хөрөнгө/ | 4.2 тэрбум иен | 14.9 тэрбум иен | 100% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | 24.5 тэрбум төгрөг | 13.7 тэрбум төгрөг | 60% |
| | | Үүнд: | Төсөв /2017 он/ | Гүйцэтгэл /2017/ | Хувь |
| | | MON-P8, MON-P12 төсөл /зээлийн хөрөнгө/ | 19.9 тэрбум иен | 13.2 тэрбум иен | 100% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | 14.4 тэрбум төгрөг | 8.1 тэрбум төгрөг | 79.06% |
| | | Үүнд: | Төсөв /2018 он/ | Гүйцэтгэл /2018/ | Хувь |
| | | MON-P8, MON-P12 төсөл /зээлийн хөрөнгө/ | 5.8 тэрбум иен | 1.8 тэрбум иен | 78% |
| | | Монголын Засгийн газрын санхүүжилт | 10 тэрбум төгрөг | 7.1 тэрбум төгрөг | 71% |
| 6. | Төсөл, хөтөлбөрийн зорилт | | | | |
| | 1-р зорилтын хүрээнд: | <p>Төслийн үндсэн гэрээний барилга, байгууламжуудын барилгын ажлыг бүрэн дуусгаг төлөвлөгөөтэй уялдуулан Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани, Ерөнхий гүйцэтгэгч болон Төслийн Ерөнхий туслан гүйцэтгэгч компаниуд өвлийн улиралд талбай дээр байрлан ажилласан болно.</p> <p>2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр гүйцэтгэгчид “Ажил хүлээн авах гэрчилгээ”-г олгосноор “Чанарын баталгаат хугацаа” эхлэх ба 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэлх нэг жилийн хугацаанд Улсын комиссын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу гишүүдийн саналын хуудсаар баталгаажсан нийт 1278 үүрэг даалгаврыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллав.</p> <p>Төслийн нэмэлт зээлийн гэрээ /MON-P12/-ний дагуу санхүүжих ажлуудыг Эдийн засгийн хамтын ажиллагааны тусгай нөхцөл /STEP/-өөр Япон Улсын бүртгэлтэй Ерөнхий гүйцэтгэгчээр хийлгэх шаардлагатай тул 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Ерөнхий гүйцэтгэгчийн “Барилгын гэрээ”-нд “Нэмэлт өөрчлөлт №1”-ийг оруулан Япон улсын “Мицүбиши-Чиёода” түншлэлээр</p> | | | |

гүйцэтгүүлж байна. Нэмэлт барилга, байгууламжууд болон Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын ажлын Ерөнхий туслан гүйцэтгэгчээр Монгол Улсын “М-Си-Эс-Проперти” ХХК ажиллаж байгаа болно.

Барилгын ажлын чанарын хяналтыг төслийн “Чанарын менежментийн тогтолцоо”-ны дагуу гүйцэтгэж байна. Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани чанарын хөндлөнгийн аудитыг тогтмол гүйцэтгэж, Ерөнхий гүйцэтгэгч, Ерөнхий туслан гүйцэтгэгчтэй чанарын баталгаажуулалтын асуудлаар хуваарийн дагуу уулзалтуудыг хийж санал солилцон ажлыг дүгнэж, холбогдох зөвлөмж зааварчилгаа өгч байна. Барилгын материалд лабораторийн шинжилгээ хийлгэн байна.

Тайлант хугацаанд Барилгын талбайн харуул хамгаалалтыг “Чингис хаан Олон улсын нисэх буудал”-ын Аюулгүй байдал, хамгаалалтын алба хариуцан ажилласан бөгөөд талбайн өдөр тутмын аюулгүй байдлын үйл ажиллагаа хэвийн явагдаж осол, зөрчилгүй ажиллав.

Улсын комисс, техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Улсын комиссоос өгсөн нийт 1278 үүрэг даалгаврын 826 нь Ерөнхий туслан гүйцэтгэгч өөрийн зардлаар 100% хийж гүйцэтгэх ажил бөгөөд ажил бүрэн хийгдэж Зөвлөх компани болон Ашиглалтын өмнөх захиргааны албаны инженерүүд хамтран шалгаж хүлээн авсан болно. Мөн Ерөнхий гүйцэтгэгч компанитай хамааралтай (Шатахууны агуулах, гидрант системийн барилга байгууламж, тоног төхөөрөмж) 66 үүрэг даалгаврыг хэрэгжүүлж хүлээн авсан 65 ажил, шалгаж баталгаажуулах шатанд 1 ажил үлдсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газар болон Ерөнхий гүйцэтгэгч “Мицүбиши-Чиёода” түншлэл хооронд байгуулсан бүтээн байгуулалтын үндсэн гэрээнд заасны дагуу ажлын тоо хэмжээ болон зураг төсөлд тусгагдаагүй аливаа ажлыг захиалагчийн хүсэлтээр хийх тохиолдолд нэмэлт төлбөрийн асуудал үүсэх юм. Иймд дээрх 1278 үүрэг даалгаврыг холбогдох талууд хамтран ангилж, ажлын даалгаварт тусгагдаагүй ажлуудыг ялгасан бөгөөд үүнээс 125 ажлыг нисэх буудлын үйл ажиллагааг хариуцах оператор компани хариуцан гүйцэтгэх боломжтой тул хасаж 112 ажлыг нэмэлт зардалтай хэмээн тодорхойлсон болно. Ингээд нэмэлт зардлаар гүйцэтгэх 112 ажлаас захиалагчийн зайлшгүй шаардлагатай гэж үзсэн 55 ажлыг гүйцэтгэгчээс үнийн санал авч нэмэлт зардлаар хийлгэсэн бөгөөд үлдсэн 57 ажлыг гүйцэтгэгч хийх боломжгүй хэмээн татгалзсан тул хийгдээгүй байна.

Нэмэлт зардлаар хийгдэх ажил тус бүрд Гүйцэтгэгчээс үнийн санал авч, хянахад цаг хугацаа их шаардагдаж байгаа нь төслийн ерөнхий туслан гүйцэтгэгч хүн хүчээ татсан, гол гол туслан гүйцэтгэгч компаниуд ажлаа дуусган буусан тул дахин хүн хүчээ эргүүлэн татах, засварлах ажилд шаардлагатай бараа материал тоо хэмжээнээс шалтгаалсан үнийн өртөг зөрүү их гарах зэрэг шалтгаанаас үнэ үлэмж өссөн санал ирүүлж байгаатай холбоотой юм. Иймд нэмэлт зардлаар хийгдэх ажлуудыг аль болох дараа нь ашиглагч байгууллага өөрийн хөрөнгөөр эсхүл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар харьцангуй хямд зардлаар гүйцэтгүүлэх тухай Төслийн удирдах хорооноос өгсөн чиглэлийг баримтлан ажиллаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 166 дугаар Захирамжаар “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын үйл ажиллагааг эхлүүлж, ашиглалтад оруулахад тулгамдаж байгаа

| | | |
|-----------------------|--|--|
| | | <p>асуудлыг судалж шийдвэрлүүлэх үүрэг бүхий Засгийн газрын Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажлын хэсэгт улсын комиссоос өгсөн үүрэг даалгавруудаас үлдсэн, нэмэлт зардал шаардлагатай тул хэрэгжих боломжгүй 57 ажлыг бүртгэлээс хасуулж хаах тухай хүсэлтийг Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар уламжлан хүргүүлээд байна. Ингэснээр Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврууд 12 сард багтан бүрэн хэрэгжиж дуусах юм.</p> <p><u>Ашиглалтын үед гарсан зөрчил дутагдлыг бүртгэх нэг жилийн чанарын баталгаажуулалтын хугацаанд илэрсэн зөрчил, дутагдлыг засварлах ажил /DNP/</u></p> <p>Захиалагч байгууллага гэрээний дагуу барилга, байгууламжуудыг хүлээн авч Чанарын баталгааны 1 жилийн хугацаа эхэлснээс хойш нийт 720 зөрчил, дутагдлыг АӨЗА-аас бүртгэж мэдэгдсэн болно. Тэдгээрээс 513 ажлыг Ерөнхий туслан гүйцэтгэгч засварлаж дууссанаас 510 ажлыг Зөвлөх компани болон Ашиглалтын өмнөх захиргааны албаны инженерүүд хамтран шалгаж баталгаажуулаад байна. Ерөнхий гүйцэтгэгчийн хариуцах 91 ажил, Зөвлөх компанийн хариуцаж буй 17 ажил болон нэмэлт зардлаар хийгдэх шаардлагатай 96 ажил байна. Мөн ашиглагч байгууллага хариуцан ашиглалтын үед шийдвэрлэх шаардлагатай 3 ажил байна.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж, зөвлөх, гүйцэтгэгч багууд болон ашиглагч байгууллагын инженерүүд 2 долоо хоног тутамд хамтарсан уулзалт хийж ашиглалтын үед илэрсэн засварлах ажлуудыг шийдвэрлэх тухай зөвшилцсөний үндсэн дээр талбайн зааварчилгаа гаргах болон албан бичгээр тайлбар өгөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.</p> <p>2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Баталгаат хугацааны засварын ажлын үүрэг даалгаврын биелэлт 85.1%-тай байна.</p> <p>Баталгаат хугацааны засварын ажлыг 2018 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Нэмэлт зардал шаардлагатай 50 ажлаас 7 ажлыг зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж гүйцэтгэгчээс үнийн санал гаргуулан хийлгэж байгаа бөгөөд үлдсэн 43 ажлыг гүйцэтгэгч хийхээс татгалзсан юм. Шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах ажлыг удирдан зохион байгуулах Засгийн газрын Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийн төлөвлөгөөнд тодотгол хийж дээрх нэмэлт зардал шаардлагатай тул хэрэгжих боломжгүй 43 ажлыг бүртгэлээс хасуулж хаах тухай саналыг Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар уламжлан хүргүүлээд байна.</p> <p style="text-align: right;">100%</p> |
| 2-р зорилтын хүрээнд: | | <p>Нэмэлт барилга, байгууламж, тэдгээрийг холбох гадна инженерийн шугам сүлжээний ажил, Ногоон байгууламж, зүлэгжүүлэлт, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн худалдан авалт, угсралтын ажлуудыг 2018 онд бүрэн гүйцэтгэж дууссан.</p> <p>“М-Си-Эс Проперти” ХХК-ийн Ерөнхий туслан гүйцэтгэгчээр ажилласан Нэмэлт барилгуудын ажил, нэмэлт барилгуудыг холбох гадна инженерийн шугам сүлжээний ажлууд 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдөр дуусаж Техникийн үзлэгийг 2018 оны 02 сарын 01-ээс 03 сарын 01-ний өдрүүдэд, Улсын комисс 2018 оны 7 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд ажилласан. Улсын комиссын дүгнэлт 2018 оны 08 дугаар сарын 14-ний өдөр гарсан.</p> <p>цахилгаан болон холбооны шугам сүлжээнд өөрчлөлт оруулсан зураг төслийг дахин экспертизээр баталгаажуулж, эцсийн байдлаар үнийн саналыг авч, Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас ажил эхлүүлэх зөвшөөрөл авч 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс барилгын ажлыг эхлүүлсэн билээ.</p> |

| | | |
|--|--|--|
| | | <p>Механик болон холбооны шугам сүлжээний ажлуудад нэмэлт гэрээний дагуу баригдаж буй газрын үйлчилгээний барилга, дулаан авто машины гараж, харуул хамгаалалтыг байрууд болон Монгол Улсын төсвөөр санхүүжиж буй 3 барилгуудыг инженерийн шугам сүлжээгээр холбох ажил багтаж байгаа ба гүйцэтгэл 100%-тай байна. 2018 оны 08 дугаар сарын 14-ны өдөр уг ажлуудад Улсын комисс ажилласан бөгөөд Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд гадна цахилгаан хангамжийн угсралтын ил далд ажлын актууд болон бусад бичиг баримтуудын бүрдлийг хангуулж, 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдөр 10/0,4кВ-ын тоног төхөөрөмж болон 10 кВ-ын кабель шугамд эрчим хүчний комисс ажиллуулан ашиглалтад оруулсан болно.</p> <p>Нэн чухал аэродромын хөөрч буух зурвас, явгалах замуудын орчмын 75 га талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж 2018 оны 07 дугаар сарын 18-ны өдөр ажил 100% дууссан болно. Энэхүү ажлыг Барилга, хот байгуулалтын Сайдын 2018 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 128 тоот тушаалаар томилогдсон Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн дүгнэлт гаргасан болно.</p> <p>Техник хэрэгслийн худалдан авалт, угсралтын ажлын хүрээнд 28 төрлийн 113 нэгж тоног төхөөрөмжийг Ерөнхий гүйцэтгэгч “Мицубиши-Чиёода” түншлэл Япон улсын худалдааны “Иточу” корпорациар дамжуулан худалдан авалтыг хийж нийлүүлсэн</p> <p>Мөн дараах бусад тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэмэлт гэрээний хүрээнд Ерөнхий гүйцэтгэгч “Мицубиши-Чиёода” түншлэлээс нийлүүлсэн. Үүнд: Хүзүүвчинд тоноглогдсон агаарын хөлгийн цахилгааны тэжээл – нийт 6 ш; Алсын удирдлага бүхий хэт богино долгионы дахин дамжуулах 2 сувгийн радиостанц (RCAG) – 2 ш; Аэродромын бодит ажиглалтын систем M-LAT 1 ком; Агаарын хөлгийн шатахуун хангамжийн системийн лабораторийн тоног төхөөрөмж – 1 ком.</p> <p>Механик болон холбооны шугам сүлжээний ажлуудад нэмэлт гэрээний дагуу баригдаж буй газрын үйлчилгээний барилга, дулаан авто машины гараж, харуул хамгаалалтыг байрууд болон Монгол Улсын төсвөөр санхүүжиж буй 3 барилгуудыг инженерийн шугам сүлжээгээр холбох ажил багтаж байгаа ба гүйцэтгэл 100%-тай байна. 2018 оны 08 дугаар сарын 14-ны өдөр уг ажлуудад Улсын комисс ажилласан бөгөөд Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Нэн чухал аэродромын хөөрч буух зурвас, явгалах замуудын орчмын 75 га талбайн зүлэгжүүлэлтийн ажлыг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж 2018 оны 07 дугаар сарын 18-ны өдөр ажил 100% дууссан болно.</p> <p>Газрын үйлчилгээний нийт 28 төрлийн 113 нэгж тоног төхөөрөмжийг Ерөнхий гүйцэтгэгч “Мицубиши-Чиёода” түншлэл Япон улсын худалдааны “Иточу” корпорациар дамжуулан худалдан авалтыг хийж нийлүүлсэн</p> <p>Мөн дараах бусад тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэмэлт гэрээний хүрээнд Ерөнхий гүйцэтгэгч “Мицубиши-Чиёода” түншлэлээс нийлүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хүзүүвчинд тоноглогдсон агаарын хөлгийн цахилгааны тэжээл – нийт 6 ш; - Алсын удирдлага бүхий хэт богино долгионы дахин дамжуулах 2 сувгийн радиостанц (RCAG) – 2 ш; |
|--|--|--|

| | | |
|--|--|--|
| | | <ul style="list-style-type: none"> - Аэродромын бодит ажиглалтын систем M-LAT 1 ком; - Агаарын хөлгийн шатахуун хангамжийн системийн лабораторийн тоног төхөөрөмж – 1 ком. <p>Захиалагчийн хүсэлтээр мөстөлтийн эсрэг шингэн цацах автомашин техникийн шаардлага хангахгүй байна гэж үзсэн тул SAFEAERO брэндийн шинэ машинаар солих асуудлыг гүйцэтгэгчтэй тохиролцоод захиалгыг хийгээд байна. Түүнчлэн зурвасны барьцалдалт хэмжигч автомашин, шатахуун сумалгааны диспенсер машинуудад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажил хийгдэж байгаа болно. Бусад машин механизм, тоног төхөөрөмжийн шаардлагатай сургалтууд, туршилт тохируулгын ажлууд бүрэн хийгдэж захиалагчид хүлээлгэн өгөөд байгаа болно.</p> <p>Түүнчлэн Нэмэлт зээлийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга, байгууламжуудын Техникийн хяналт үзлэгт Төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн баг бүрэн бүрэлдэхүүнээр Ашиглалтын өмнөх захиргааны албаны инженерүүдтэй хамтран оролцож нийт 689 зөрчил дутагдал илрүүлсэн. Эдгээр зөрчил дутагдлыг арилгах ажилд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Улсын комисс ажиллуулах бэлтгэлийг ханган техникийн комиссоос гаргасан үүрэг даалгаврууд дийлэнх нь хэрэгжсэн тул Гүйцэтгэгчээс ирүүлсэн саналын дагуу Улсын комисс ажиллуулах хүсэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд тавьсан бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдөр 01/2887 тоот албан бичгээр Барилга хот байгуулалтын яаманд Улсын комисс томилуулах хүсэлтийг хүргүүлсэн билээ.</p> <p>Улмаар Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 128 дугаар тушаалаар Улсын комисс томилогдож 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд талбай дээр ажиллав. Энэ хугацаанд барилга, байгууламжуудын техникийн тодорхойлолт, батлагдсан зураг, шаардлагын дагуу шалгаж нийт 37 үүрэг, даалгавар өгсөн юм. Үүнээс 28 ажлыг туслан гүйцэтгэгч, 6 ажлыг Зөвлөх компани, 2 ажлыг Төсөл хэрэгжүүлэх нэгж, 1 ажлыг Иргэний нисэхийн ерөнхий газар хариуцахаар байв. Одоогийн байдлаар 35 ажил бүрэн хэрэгжиж, туслан гүйцэтгэгчийн хариуцах 2 ажил хэрэгжих шатандаа байна.</p> <p>Хэрэгжих шатандаа байгаа 2 ажлын нэг нь техникийн комиссын гаргасан коментуудыг бүрэн хэрэгжүүлэх гэсэн заалт байгаа тул техникийн үзлэгээс гаргасан 689 ажлын биелэлтийг гарган хавсаргаж биелэлтийг тайлагнаж байгаа болно. Өнөөдрийн байдлаар 514 ажил бүрэн хэрэгжиж 146 ажил хэрэгжих шатандаа, үлдсэн 29 ажил нь нэмэлт зардал шаардлагатай ажлууд юм. Гүйцэтгэгчийн ажлын даалгаварт тусгагдаагүй, нэмэлт зардал шаардлагатай эдгээр 29 ажлыг холбогдох тайлбар хийж хаах саналыг Зам, тээврийн хөгжлийн дэд сайдад албан бичгээр хүргүүлээд байна.</p> <p style="text-align: right;">98.6 %</p> |
| | <p><u>3-р зорилтын хүрээнд:</u></p> | <p><u>Захиргааны барилга, Аэродромын засвар үйлчилгээний барилга, Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга</u></p> <p>Захиргааны барилга, Аэродромын засвар үйлчилгээний барилга, болон Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилгын гүйцэтгэгчээр “Ви Эйч энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэл Зам, тээврийн яамтай /хуучин нэрээр/ 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 113/14 тоот гэрээ, 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 29 тоот нэмэлт гэрээг тус тус байгуулсан. Урьдчилгаа санхүүжилт болон гүйцэтгэлийн санхүүжилтийг цаг тухайд нь олгоогүйн улмаас гэрээт хугацаанд ажлыг бүрэн дуусгах боломжгүй болсон.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн яамнаас гүйцэтгэгчийн гэрээг дүгнэх ажлын хэсэг томилон холбогдох байгууллагуудтай хамтарсан</p> |

| | | |
|--|--|--|
| | | <p>хурлыг төслийн талбай дээр 2017 оны 11 дүгээр сарын 17–ны өдөр, 11 дүгээр сарын 29-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд тус тус хуралдаж гэрээг сунгах тухай шийдвэрлэсэн. Талууд 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 326 дугаартай нэмэлт гэрээг байгуулж хугацааг 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан.</p> <p>Тус нэмэлт гэрээнд захиргааны барилгыг 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр, Аэродромын засвар үйлчилгээний барилга болон Ачаа шуудан, тээврийн үйлчилгээний барилга угсралтын ажлыг 2018 оны 07 дугаар сарын 21-нд тус тус гүйцэтгэж дуусгахаар тусгагдсан болно.</p> <p>Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга, Аэродромын үйлчилгээний барилгын дотор засал, салхивч, дулаан, ус хангамжийн ажлууд тус тус хийгдэж байна.</p> <p>Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн баталгаажсан ажлын гүйцэтгэл 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар:</p> <p>Захиргааны барилга -98.0 % Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга- 85.9% Аэродромын засвар үйлчилгээний барилга -87.8 % Нийт гүйцэтгэл 90.6 %</p> <p>Төв аймгийн Засаг даргын тамгын газраас томилогдсон Захиргааны барилгыг ашиглалтад оруулах улсын комисс 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Барилгын хөгжлийн төв, Төсөл хэрэгжүүлэх нэгж, зураг төсөл зохиогч “Говь Травэл” ХХК, ИНЕГ-ын харьяа Ашиглалтын өмнөх захиргааны алба, болон Төв аймгийн холбогдох газруудын төлөөлөл бүхий 22 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж 14 хоногийн дотор Улсын Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр барилгыг байнгын ашиглалтанд хүлээж авахаар шийдвэрлэв. Барилгын хөгжлийн төв комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр шалгаж биелэлт хангалттай гэж дүгнэсэн. Энэ дүгнэлтийн дагуу 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Гүйцэтгэгч, ТХН, ИНЕГ-ийн Ашиглалтын өмнөх захиргаа алба /АӨЗА/ ба Төв аймгийн Засаг даргын тамгын газраас томилогдсон гишүүд, комиссын нарийн бичгийн дарга нар барилга дээр үзлэг шалгалт хийж 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн ХОХБТХ 65/18 дугаартай Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр Захиргааны барилгыг ашиглалтад оруулах шийдвэр гаргасан.</p> <p>АӨЗА болон гүйцэтгэгч “Ви Эйч энд Би” ХХК хооронд байгуулах нэмэлт гэрээ хэлэлцэгдэж байна. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн бичгийн даргын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 391 тоот тушаалаар Гүйцэтгэгчтэй байгуулсан 113/14 дугаартай гэрээний нэмэлт 326 дугаартай гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">90.6 %</p> |
| | <p><u>4-р зорилтын хүрээнд:</u></p> | <p>Монгол Улсын Засгийн газар Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА хооронд 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн Зээлийн гэрээ MON-R12”-ний ашиглагдаагүй үлдэгдэл хөрөнгөөр Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга /цаашид Ангар гэх/-ын ажлыг санхүүжүүлэх саналыг Зам, тээврийн хөгжлийн яам гаргаж зээлдүүлэгч ЖАЙКА байгууллага зөвшөөрсний дагуу Ангарын барилгыг зээлийн үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэн барих ажлын судалсан.</p> |

| | |
|--|---|
| | <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд Шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгамдаж буй асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат танилцуулснаар тус хуралдааны 36 дугаар тэмдэглэлийн 7.2-т Ангарын барилга, агаарын хөлгийн явгалах зам, зогсоол, дэд бүтцийн шугам сүлжээ, газар шорооны ажил болон зураг төслийг Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн зээлийн үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх асуудлуудыг судлан зохих журмын дагуу шийдвэрлэхийг Сангийн сайд болон Зам, тээврийн хөгжлийн сайд нарт даалгасан болно.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн зээлээс үлдэж байгаа хөрөнгөөр Ангарын барилга, түүний дэд бүтэц, зогсоол, явгалах зам болон бусад зам талбайг барих боломжийг судалж, холбогдох арга хэмжээ авахыг Төсөл хэрэгжүүлэх нэгжид үүрэг болгосны дагуу Ангарын барилгын ажлын даалгаврын төслийг бэлтгэх ажлыг зохион байгуулж холбогдох газруудаас санал авч, Иргэний нисэхийн ерөнхий газраас хянуулан, Зам, тээврийн хөгжлийн сайдаар батлуулсны үндсэн дээр Ангарын барилгын зураг төсөл боловсруулах ажлыг Зөвлөх компани 2017 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлүүлж ажилласан.</p> <p>Төслийн ерөнхий төлөвлөгөөнд заагдсан байрлалд Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга /Ангар/-ын талбай бэлдэх ажлын хүрээнд өндөржилтийг тогтоож хөрс хуулах ажлыг 2017 оны 10, 11 сард хийж гүйцэтгэсэн.</p> <p>Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг Төв аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраар 2018 оны 01 дүгээр сарын 17-нд батлуулсан. ЗТХЯ дээр агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын зургийн даалгаварт нэмэлт өөрчлөлт хийгдсэн бөгөөд холбогдох тайлбаруудыг бэлтгэж зургийн экспертизад хүргүүлсэн. 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр уг барилга, туслах барилгууд болон холбох гадна шугам сүлжээний зураг төслийн баримт бичигт магадлалын ерөнхий дүгнэлт гарсан.</p> <p>Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга, туслах барилгууд болон холбох гадна шугам сүлжээний барилга угсралтын ажлыг дараах 6 багцад хуваан хэрэгжүүлэхээр Зөвлөх компани болон Ерөнхий гүйцэтгэгчтэй тохиролцсон. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Багц 1А - Агаарын хөлгийн явгалах зам болон перрон, барилгын гадна авто зам болон зогсоолууд 2. Багц 2А - Барилгын ган бүтээц, хана дээврийн угсралт 3. Багц 2В - Барилгын суурь, шалны ажил 4. Багц 3Е - Дотор болон гадна цахилгаан, холбоо дохиоллын угсралт 5. Багц 3М - Дотор болон гадна цэвэр, бохир, халаалтын шугам 6. Багц 3R - Оффисын барилга <p>Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга угсралтын ажил гүйцэтгэх хүсэлт ирүүлж буй компаниудын мэдээллийг тухай бүрт нь Зөвлөх компанид хүргүүлж, тухайн компаниудын шаардлагатай мэдээллийг холбогдох яам, газруудаас авч Зөвлөх компанид дэмжлэг үзүүлэн ажилласан. Багц 1А, Багц 2А, Багц 2В ажлуудын гүйцэтгэгч зохих журмын дагуу шалгарсан бөгөөд бусад багцуудад хамаарах ажлуудын зардлын тооцооллуудыг нягтлах, баталгаажуулах судалгаа хийгдэж байна.</p> <p>Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын барилга угсралтын ажлыг 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдөр албан ёсоор эхлүүлж 2019 оны 12 дугаар сард дуусгах төлөвлөгөөтэй</p> |
|--|---|

| | | |
|----|--|--|
| | | ажиллаж байна. 90.1% |
| | 5-р зорилтын хүрээнд: | <p>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 7 хоног тутам шуурхай хурал хийж, ажлын явц байдлыг хэлэлцэж цаг хугацаа алдахгүй шийдвэрлэх асуудлын явц байдлыг дүгнэж, тулгамдсан ажлуудыг тодорхойлон ажиллаж байна.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж, Ашиглалтын өмнөх захиргааны алба, Зөвлөх, Гүйцэтгэгч, Ерөнхий туслан гүйцэтгэгч талууд хамтран Техникийн комисс, Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон чанарын баталгаат хугацааны үед буюу ашиглалтын явцад илэрсэн алдаа дутагдлыг засварлах ажлын явцын талаар тогтмол хэлэлцэж байна. Ээлжит хурал зохион байгуулагдаж, шийдвэрлэх асуудлын явц байдлыг дүгнэн, тулгамдсан ажлуудыг тодорхойлон ажиллаж.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани, Ерөнхий гүйцэтгэгч, Ерөнхий туслан гүйцэтгэгчийн 7 хоног тутам хамтарсан уулзалтыг төслийн талбайд дахь хурлын танхимд хийж Гүйцэтгэгчийн өнгөрсөн 7 хоногийн ажлын тайланг хэлэлцэж дүгнэн холбогдох чиглэл өгч ажиллав.</p> <p>Монгол 3 барилгуудын гүйцэтгэгч “Ви Эйч энд Би” ХХК болон Захиалагчийн хяналт хийж буй Барилгын хөгжлийн төвтэй 7 хоног тутам барилгын явцын хурал хийж байна.</p> <p>Төслийн хүрээнд ашиглах бараа, материал, тоног төхөөрөмжүүдийг ажлын талбайд татан авах ажил хэвийн явагдаж байна. Эдгээрээс импортоор оруулах бараа, материал, тоног төхөөрөмжийг Монгол Улсын гаалийн татвар хураамжаас чөлөөлүүлэн хугацаанд нь цаг алдалгүй хилээр нэвтрүүлэх талаар холбогдох яам, газруудтай уялдаатай ажиллаж, ажлын талбайд буусан материал, тоног төхөөрөмжийг төлөвлөгөөтэй уялдуулан ажлын талбайд татан авчрах ажил болон тоо хэмжээнд хяналт тавьж ажилладаг болно. Импортоор оруулах материал, тоног төхөөрөмжийн жагсаалт, холбогдох баримт бичгүүдийг төслийн Зөвлөх компанийн хамт хянаж баталгаажуулан Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж ажиллаж байна.</p> <p>100%</p> |
| 7. | Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/ | <p>Төслийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажлууд төлөвлөгөөний дагуу хэвийн хэрэгжиж байна.</p> <p>2018 онд Төслийн Ерөнхий туслан гүйцэтгэгчээр үндэсний компани ажилласан нь дотоодын мэргэжлийн ажиллах хүчнээр бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгүүлж, төсөл дээр ажиллаж буй гадаадын болон дотоодын туршлагатай инженерүүдээс ихийг суралцах, дадлага туршлагаа нэмэгдүүлэх, төслийн бичиг баримтыг олон улсад мөрдөгдөг заавар, зөвлөмжийн дагуу боловсруулж ажиллах боломжоор хангагдсан нь ололт байлаа.</p> <p>Энэхүү төсөл нь Олон улсын гэрээ болон Фидик буюу олон улсын зөвлөх инженерүүдийн холбооны загвар гэрээний дагуу хэрэгжиж, гэрээний зарим заалтууд Монгол Улсын хууль тогтоомжтой зөрүүтэй байдал үүсэх, энэ тохиолдолд зөрчил үүсэж, ажлыг явуулахад зарим талаар ажилд саад учрах тохиолдол гарч байлаа. Тухайлбал, Гэрээ байгуулахын өмнө Тендерийн үе шатанд барилгын ажлын гадаад гүйцэтгэгч нь тухайн улс орондоо тусгай зөвшөөрөл авсан байвал түүнийг дүйцүүлэн ашиглах талаар албан ёсоор тохиролцсоны дагуу өнөөдөр төслийн Ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нар өөрийн оронд олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу ажиллаж байгаа болно. Гэвч Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төлөвлөгөөт хяналт шалгалтаар Монгол Улсад барилгын тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулах албан шаардлагыг биелүүлж ажиллахыг шаарддаг болно.</p> <p>Монгол улсын Засгийн газрын санхүүжилтээр Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга, Захиргааны барилга,</p> |

| | | | | | | | | |
|-----|---|---|---------------------|--------------|-------------|-------------|-------------|--------------|
| | | <p>Аэродромын засвар үйлчилгээний барилгын ажлыг гүйцэтгэж байна. Барилгын ажлыг гүйцэтгэх тендерийн шалгаруулалт удааширсан, бүтээн байгуулалтын ажил хугацаа хоцорч байгаа нь нийт төслийн ажлын явцад нөлөөлж, шинэ нисэх буудлыг оруулахад сөрөг нөлөө үзүүлж байна.</p> <p>Шинэ нисэх буудалд холбогдох хурдны авто замын ажил энэ онд эрчимтэй хийгдэж шинэ нисэх буудал ашиглалтад оруулах үеэр хурдны авто замтай байхаар төлөвлөн ажиллаж байгаа нь төслийн хэрэгжилтэд ихээхэн хувь нэмэр болж байна.</p> <p>Сонгино 220/110/35 кВ-ын 2х125 МВа чадалтай Дэд станцын барилгын ажлууд хоцорч байгаа нь төслийн барилгын ажлыг хугацаанд нь дуусгах, Нисэх онгоцны шинэ буудлыг хугацаанд нь ашиглалтад оруулахад сөргөөр нөлөөлж болзошгүй тул уг ажлыг эрчимжүүлэх талаар холбогдох яам, газрууд анхаарах шаардлагатай байна.</p> | | | | | | |
| 8. | Төслийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ | Төслийн хэрэгжүүлэгч талуудын хоорондын хамтын ажиллагаа сайн байна. | | | | | | |
| 9. | Төслийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт | Биелэлт дундаж % | Зорилтууд | | | | | |
| | | | Зорилтын тоо | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | | 95.06% | 5 | 100.0 | 98.6 | 90.6 | 90.1 | 100.0 |
| 10. | Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗТХЯ-ны үнэлгээ/ | | | | | | | |